



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/23

Алтай хот

**Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар тушаалаар баталсан "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй гэрч, хохирогч, хүүхдэд туслалцаа үзүүлэн, зөвлөгөө өгч эрх ашгийг нь хамгаалах чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хорооны үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган үйл ажиллагааны тайлан, шаардлагатай тохиолдолд нөхцөл байдлын мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас бүтэн жилээр танилцуулж, жилд нэг удаа Хүүхдийн төлөө зөвлөлд тайлагнан ажиллахыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо (Д.Алтанзагас)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 19-ны өдрийн 41/23 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ДЦА 0042

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -(Аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд: -(Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)
- (Шүүхийн Тамгын газрын дарга)
- (Аймгийн Ерөнхий прокурор)
- (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
- (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
- (Эрүүл мэндийн газрын дарга)
- (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
- (Цагдаагийн газрын дарга)
- (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга)
- (Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь ахлах мэргэжилтэн)
- (Өмгөөлөгчдийн холбооны дарга)
- (Хүүхэд, гэр бүлд үйлчилдэг төрийн бус байгууллагын төлөөлөл) (зөвшилцсөнөөр)
- (Хүүхдийн элч) (зөвшилцсөнөөр)
- Нарийн бичгийн дарга:-(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

__оОо__